Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын даргын 2023 оны 150 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- Сангийн сайдын 112 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай";

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,906,828.6 мянган төгрөгөөр буюу 20.0 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	352,489.0	500,847.6	148,358.6
Авлага	100.0	100.0	-
Урьдчилгаа	9,150,811.9	2,774,915.4	(6,375,896.5)
Бараа материал	142,055.8	155,670.6	13,614.8
Нөөцийн бараа	-	4,783,627.3	4,783,627.3
Үндсэн хөрөнгө	5,941,182.6	11,278,307.0	5,337,124.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>15,586,639.3</b>	<b>19,493,467.9</b>	<b>3,906,828.6</b>
Өр төлбөр	332,489.0	489,479.6	156,990.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	15,254,150.3	19,003,988.3	3,749,838.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>15,586,639.3</b>	<b>19,493,467.9</b>	<b>3,906,828.6</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнө оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 500,847.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 148,358.6 мянган төгрөгөөр өссөн нь 355,380.0 мянган төгрөгийн барьцааг

төвлөрүүлж, 257,601.0 мянган төгрөгийн барьцаа чөлөөлж, ахмадын сангийн орлого 5,000.0 мянган төгрөгийг цалингийн сангаас төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Авлагын дансанд утасны дугаарын барьцаа 100.0 мянган төгрөг бүртгэлтэй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 2,774,915.4 мянган төгрөг болж 6,375,896.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд бараа материал бэлтгэхэд 1,406.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө бэлтгэх 2,773,508.6 мянган төгрөгийн урьдчилгааны зардал гарснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 155,670.6 мянган төгрөг болж 13,614.8 мянган төгрөгөөр өссөн нь 78,161.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, газрын даргын тушаалаар 3,737.0 мянган төгрөгийн эвдэрч муудсан, ашиглалтын шаардлага хангахгүй бараа материалыг акталж, 60,809.7 мянган төгрөгийн бараа материал үйл ажиллагаандаа зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын нөөц данс 4,783,627.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Түүнд Агро сити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах төслийн санхүүжилт 1,392,000.0 мянган төгрөг, Зайсан орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын 291,500.0 мянган төгрөг, Нийслэл хотын нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох 1,679,923.4 мянган төгрөг, барилгажилтын төсөл олон улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах 761,643.9 мянган төгрөг, Сэлбэ дэд төв орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн ТЭЗҮ, Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хот байгуулалтын баримт боловсруулах ажлын санхүүжилтийн ТЭЗҮ-г бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,278,307.0 мянган төгрөг болж 5,337,124.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд газрын даргын А/37, А/57, А/58 А/60 дугаар тушаалаар 9,526,025.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, 264,125.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, НӨХГ-ын 1/1812 дугаар тушаалаар 360,425.4 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг орлогоор бүртгэж, НӨХГ-ын 2025 оны А/80, А/305, А/306, А/642 дугаар тушаалаар 61,700.0 мянган төгрөгийн авто машиныг НГЗБА-нд, 37,222.5 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг НӨХГ-т, 3,099,815.9 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг НОСБГ-т, 794.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг НХШГ-т балансаас баланст шилжүүлэн өгч, 541,122.5 мянган төгрөгийн программ хангамж, 109,940.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг данс бүртгэлээс хасаж акталж, элэгдлийн зардлыг тооцож бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 489,479.6 мянган төгрөг болж 156,990.6 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд "УБ Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гэрээний барьцаа 232,481.2 мянган төгрөг, Сэлбэ дэд төв орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл, олон улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах ажлын барьцаа 177,690.0 мянган төгрөг, Газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийг тодорхойлох зорилгоор хөрсний хурдатгал бичигч станцын багаж тоног төхөөрөмж худалдан авах ажлын барьцаа 4,420.3 мянган төгрөг, Зайсан орчмын хэсэгчилсэн ерөнхий

төлөвлөгөө боловсруулах ажлын гэрээний барьцаа 79,500.0 мянган төгрөг, нийт 332,489.0 мянган төгрөгийн барьцааг бүртгэж, гэрээний ажил дууссан 257,601.0 мянган төгрөгийн 9 аж ахуйн нэгж, байгууллагын барьцааг чөлөөлснөөс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 19,003,988.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,749,838.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус хэлтсийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 5,794,224.0 мянга, нийт зарлагыг 5,794,224.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 311,158.8 мянган төгрөгөөр бууруулж 5,483,085.2 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 204,090.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 668.2 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 597.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 231,828.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 181,926.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 42,425.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 38,854.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлаас 12,205.0 мянган төгрөг, норматив, томилолт зочны зардлаас 2,775.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 5,394,042.6 мянган төгрөгөөр баталж нэг удаа тодотгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,831,847.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,837,886.4 мянган төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 14,634.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,951,847.3 мянган төгрөг буюу 73.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 1,168,156.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 50,493.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 39,325.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлаас 33,632.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 17,850.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 9,222.6 мянган төгрөг, норматив зардлаас 987.0 мянган төгрөгийг тус тус гүйцэтгэлээр зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71503- Хот суурины ерөнхий төлөвлөлт	5,394,042.6	3,951,847.3	1,442,195.3	73.3%
1.1	80101-Үндсэн үйл ажиллагаа	5,208,271.6	3,823,252.6	1,385,019.3	
1.2	80802- ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	185,771.0	128,595.1	57,175.8	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд НЗД-ын А/33 дугаар захирамжаар 4,400.0 мянган төгрөг, НИТХ-аас барилга, байгууламжид газар хөдлөлийн үнэлгээний төлбөрт 187,900.1 мянган төгрөг, хөрсний хурдатгал хэмжигч багаж худалдан авахад 88,407.0 мянган төгрөг, ГХУСАЗ Нийслэлийн салбар зөвлөлийн А/64 дугаар тогтоолоор Хотын стандартын баримт бичгийн хэвлэлийн зардал, Хот, суурин газрын зам тээврийн ослын үед нисгэгчгүй нисэх дрон, замын хөдөлгөөний дундаж хурдны камерт тавигдах төслийн санхүүжилт 47,415.0 мянган төгрөг нийт 328,122.1 мянган төгрөгийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 4 хөтөлбөрийн 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	"Дарь-Эх" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД 27-р хороо/	НХААГ-21/176/2 2021.10.01-2022.01.29 НХААГ-21/176/2-01 2022.01.29-2022.03.28	80.0%	115,010.5	92,008.4
2	"Монель" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД 4,5-р хороо/	НХААГ-21/176/3 2021.10.01-2022.01.29 НХААГ-21/176/3-01 2022.01.29-2022.03.28	80.0%	115,010.5	92,008.4
3	"Тахилт" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /СХД 33-р хороо/	НХААГ-21/176/1 2021.10.01-2022.01.29 НХААГ-21/176/1-01 2022.01.29-2022.03.28	80.0%	115,010.5	92,008.4
4	"Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ	НХААГ/20240103147 2024.05.27-2024.08.24 НХААГ/20240103147-1 2024.08.26-2024.09.30	100%	4,649,625.0	4,649,625.0
5	Зайсан орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гэрээ	НХААГ/20240103246 2024.06.20-2024.12.14, 2024.12.14-2025.09.02	100%	530,000.0	530,000.0
6	"Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох"	НХААГ/20240103238 2024.06.17-2024.11.15 2025.08.15	60.0%	5,599,744.6	3,359,846.8

7	"Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт боловсруулах ажлын гэрээ	2024/ХЕТ-01 2024.11.04-2025.03.17 2024/ХЕТ-01-01 2025.03.17-2025.09.17, 2024/ХЕТ-01-01 2025.03.17-2026.07.09,	40.0%	1,646,400.0	658,560.0
8	"Сэлбэ дэд төв" орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах ажлын ТЭЗҮ, зураг төсөл, зөвлөх үйлчилгээ боловсруулах ажил	ЗЧ2025/01-2025.04.21-2025.08.15	100%	3,553,800.0	3,553,800.0
9	"Сэлбэ дэд төв" орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл, олон улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах	НХААГ20231392/01 2024.04.08-2024.09.20 НХААГ202311392/01-01 2024.09.23-2024.12.31	55.0%	533,100.0	293,158.5
10	Агро сити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил	НХААГ/20250103049 25.06.25-25.12.21	35.0%	2,320,000.0	812,000.0
<b>Нийт</b>			<b>72.0%</b>	<b>19,177,701.1</b>	<b>13,777,635.5</b>

Хэрэгжилт нь дутуу байгаа 7 төсөл хөтөлбөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт орж 2026 оны хөрөнгө оруулалтын ажилд төлөвлөгдсөн байна

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Нийслэл дэх Төрийн аудитын газрын санхүүгийн аудитын албаны аудитор Г.Тэмүүжин гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нийслэлийн дэх Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/118 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 5,139,244.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 77,088.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд тус байгууллага нь зардлыг хэмнэх арга хэмжээ авч үндсэн үйл ажиллагааны орлогоос 14,601.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж хэмнэлт бий болгожээ.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, байгууллагын батлагдсан орон тоонд орсон еерчлөлт зэргийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;” 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” 6.4.9-д “хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл;” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд тогтоосон хугацаанд бүрэн мэдээлэл оруулах зөвлөмж өгөв

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Цахим дэлгүүрт байршсан 14,557.4 мянган төгрөгийн барааг бусад этгээдээс худалдан авсан байна. Өмнөх оны аудитын зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө, 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна", Төсвийн тухай хуулийн 24 дүрээг зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно;" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад хамруулаагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 58,346.1 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	58,346.1	5	58,346.1	100%
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>58,346.1</b>	<b>5</b>	<b>58,346.1</b>	

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгө оруулалтын ажлын ТЕЗҮ-г биет бус хөрөнгөд бүртгэж элэгдлийн зардал тооцож байгааг Сангийн сайдын А/3 дугаар тушаалд нийцүүлэн НБББББ-т тусгах асуудлыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,616,015.0 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

**Залруулсан алдаа:**

- Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 2,616,015.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд дансны зүйл зөрүүлэн бүртгэсэн байна.
- Төсвийн хөрөнгөөр байгууллагын албан хаагчдад ажлын хүрэм хийлгэхэд зарцуулсан 2,475.0 мянган төгрөгийг аудитын явцад холбогдох албан тушаалтнаар бүрэн төлүүлж, зөрчлийг арилгасан тул залруулгаар бүртгэв.

Энэ нь "УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх;" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгийг тодруулга тайланд дансны зүйл анги буруу тусгасан байна.	1	2,616,015.0	-	-	1	2,616,015.0	1	2,616,015.0	-	-	-	-
Төсвийн хөрөнгөөр байгууллагын албан хаагчдад ажлын хүрэм хийлгэхэд зарцуулсан 2,475.0 мянган төгрөгийг аудитын явцад холбогдох албан тушаалтнаар бүрэн төлүүлж, зөрчлийг арилгасан тул залруулгаар бүртгэв.	1	2,475.0	-	-	-	-	1	2,475.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,618,490.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>2,616,015.0</b>	<b>1</b>	<b>2,618,490.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны мэдээллийг хугацаандаа мэдээлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим худалдан авалт хийгээгүй. Өмнөх оны аудитын шийдвэрийн хэрэгжүүлээгүй байна.	1	14,557.4	-	-	1	14,557.4	-	-	-	-	-	-
Дүн	2	17,032.4	1	2,475.0	1	14,557.4	-	-	-	-	-	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 189/А0271194

Улаанбаатар хот

НТАГ-2026/564/НА-СТН-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд хүсэлт илгээж, 14,557,515.00 (арван дөрвөн сая таван зуун тавин долоон мянга, таван зуун арван тавь) төгрөгийн бичиг хэргийн материалыг худалдан авалт хийгээгүй өмнөх оны зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөө болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 38 дугаар зүйлийн 38.1-д "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" Төсвийн тухай хуулийн 24 дүрээг зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтуудад заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, төрийн худалдан авах цахим системээс худалдан авалт хийгээгүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090289

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалт, хотын стандартын газрын дарга Г.Баярсайхан, нягтлан бодогч Н.Лхам нарт даалгав .

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Д.ОТГОНБАЯР

Г.ТЭМҮҮЖИН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар